



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/219/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМАН ДАХЬ СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/127
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЛҮН СУМАН ДАХЬ
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Ж.ГОМБОСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн анги нь Лүн, Баянхангай сумдын Монгол-Солонгосын Ногоон хэрэм төслөөс хүлээлгэн өгсөн 500 га ойн зурвас, Мод үржүүлгийн 20 га газрыг хариуцан усалгаа, арчилгааг хийж, шинээр үр болон мөчрөөр 63,600 ширхэг тарьц, мод тарих үндэсний өдрөөр 11 төрлийн 20,550 ширхэг тарьц, намар 4,650 ширхэг тарьцыг аймгийн албан байгууллагын хүсэлтийн дагуу өгсөн байна. Нийт мод үржүүлгийн газарт 13 төрлийн 232,125 ширхэг тарьц ургаж, сургалтын төвийн үйл ажиллагаатай давхардсан тоогоор 350 гаруй зочид ирж танилцсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5,203.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас 74,970.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.
- Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 0 төгрөг, эцсийн үлдэгдэл 2,855.1 мянган төгрөг болж 2,855.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Энэ нь аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/13 тоот захирамжаар тус байгууллагын орон тоо бүтцийг 42 байхаар баталсан байна.

- Тус байгууллага тайлант онд цалингийн зардлаас үндсэн 7 ажилтан, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 10 гэрээт ажилчдын цалин олгож, төсөвт орон тоо, цалингийн зардлыг дутуу баталснаас НДШ, ХАОАТ-т өр үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,229,500.80	21,250,630.80
33	АВЛАГА	20,232,000.00	0
33500	Бусад авлага	20,232,000.00	0
33510	Байгууллагаас авах авлага	20,232,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	8,997,500.80	21,250,630.80
35100	Түүхий эд материал	2,380,950.80	2,380,950.80
35110	Тусгай зориулалттай материал	2,380,950.80	2,380,950.80
35400	Хангамжийн материал	6,616,550.00	18,869,680.00
35410	Бичиг хэргийн материал	55,000.00	396,700.00
35420	Аж ахуйн материал	1,904,250.00	3,304,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	517,000.00	1,990,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,140,300.00	13,178,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	30,818,833.28	93,386,411.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	30,818,833.28	93,386,411.73
39200	Биет хөрөнгө	30,818,833.28	93,386,411.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,900,000.00	105,870,073.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,287,500.01	-17,891,261.16
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,540,000.00	6,743,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-333,666.71	-1,335,400.11
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	60,048,334.08	114,637,042.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	2,855,091.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	2,855,091.91
41300	Өглөг	0	2,855,091.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	2,855,091.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	60,048,334.08	111,781,950.62
51	Засгийн газрын хувь оролцоо	60,048,334.08	111,781,950.62
51200	Хуримтлагдсан үр дүн	60,048,334.08	111,781,950.62
51210	Өмнөх үеийн үр дүн	7,773,649.97	60,048,334.08
51220	Тайлант үеийн үр дүн	52,274,684.11	51,733,616.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	60,048,334.08	114,637,042.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	132,404,450.80	257,400,373.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,280,950.80	74,970,073.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,280,950.80	74,970,073.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	30,900,000.00	74,970,073.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,380,950.80	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	99,123,500.00	182,430,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,514,800.00	20,232,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,514,800.00	20,232,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,608,700.00	162,198,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,608,700.00	162,198,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	80,129,766.69	205,666,756.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,129,766.69	205,666,756.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	59,897,766.69	205,666,756.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,718,800.00	49,327,040.49
210101	Үндсэн цалин	44,718,800.00	42,131,509.49
210102	Нэмэгдэл	0	7,195,531.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,589,900.00	9,567,892.42
210201	Тэтгэврийн даатгал	3,801,100.00	7,499,092.42
210202	Тэтгэмжийн даатгал	447,200.00	517,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,800.00	413,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	89,400.00	189,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	894,400.00	948,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,317,502.00	3,347,600.00
210401	Бичиг хэрэг	290,400.00	97,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,470,802.00	3,250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	556,300.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	368,390.00
210604	Урсгал засвар	0	368,390.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	103,418,339.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	103,138,939.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0	26,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,471,564.69	37,837,494.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,081,398.00	20,232,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,390,166.69	17,605,494.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,232,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,232,000.00	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,232,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	52,274,684.11	51,733,616.54
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	52,274,684.11	51,733,616.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	78,891,500.00	202,662,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,567.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	145,567.00	00.00
120009	Бусад орлого	145,567.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,745,933.00	202,662,300.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	476,800.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	22,806,000.00	20,232,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,232,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,574,000.00	20,232,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,463,133.00	182,430,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	55,463,133.00	182,430,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	78,891,500.00	197,459,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	78,891,500.00	197,459,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	58,659,500.00	197,459,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	44,718,800.00	51,718,800.00
210101	Үндсэн цалин	44,718,800.00	45,162,562.00
210102	Нэмэгдэл	00.00	6,218,942.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	337,296.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,589,900.00	6,982,100.00
210201	Тэтгэврийн даатгал	3,801,100.00	4,913,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	447,200.00	517,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	357,800.00	413,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	89,400.00	103,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	894,400.00	1,034,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,578,600.00	3,550,000.00
210401	Бичиг хэрэг	326,000.00	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,074,000.00	3,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	178,600.00	00.00
2105	Нормативт зардал	550,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	00.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	145,400.00	110,076,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	109,797,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	26,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,276,800.00	20,232,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,276,800.00	20,232,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,232,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,232,000.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,232,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	5,203,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	5,203,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	5,203,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	5,203,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	5,203,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-5,203,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	7,773,649.97	7,773,649.97
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	7,773,649.97	7,773,649.97
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	52,274,684.11	52,274,684.11
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	60,048,334.08	60,048,334.08
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	60,048,334.08	60,048,334.08
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	60,048,334.08	60,048,334.08
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	51,733,616.54	51,733,616.54
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	111,781,950.62	111,781,950.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	182,430,300.00	182,430,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	182,430,300.00	182,430,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	182,430,300.00	182,430,300.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	51,718,800.00	51,718,800.00
210101	Үндсэн цалин	44,718,800.00	43,823,635.00
210102	Нэмэгдэл	7,000,000.00	4,831,165.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	3,064,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,982,100.00	6,982,100.00
210201	Тэтгэврийн даатгал	4,913,300.00	4,913,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	517,200.00	517,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	413,800.00	413,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	103,400.00	103,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,034,400.00	1,034,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,550,000.00	3,550,000.00
210401	Бичиг хэрэг	250,000.00	176,636.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	3,300,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	73,364.00
2105	Нормативт зардал	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	2,500,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,800,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,279,400.00	115,279,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	115,000,000.00	115,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	108,000.00	108,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	50,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	26,000.00	26,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	182,430,300.00	182,430,300.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	182,430,300.00	182,430,300.00
320001	Орон нутгийн төсвөөс	182,430,300.00	182,430,300.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	6	6
620003	Үйлчлэх ажилтан	0	0
620004	Гэрээт ажилтан	10	10

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,232,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,232,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,232,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,232,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,232,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,232,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,232,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,232,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн анги нь төрөөс ойн талаар баримтлах бодлогын төлөвлөгөөний хэрэгжилт, ойг хамгаалах зүй зохистой ашиглах үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж хамтын менежментийг хэрэгжүүлсэн, ойг нөхөн сэргээх байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг нэмэгдүүлэх, ойн хортон, ойн талаар хэрэгжүүлж буй бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг тооцох, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, Ногоон хэрэм төслөөс хүлээн авсан ойжуулалтын талбайн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн анги нь Лүн, Баянхангай сумдын Монгол-Солонгосын Ногоон хэрэм төслөөс хүлээлгэн өгсөн 500 га ойн зурвас, Мод үржүүлгийн 20 га газрыг хариуцан усалгаа, арчилгааг хийж, шинээр үр болон мөчрөөр 63,600 ширхэг тарьц, мод тарих үндэсний өдрөөр 11 төрлийн 20,550 ширхэг тарьц, намар 4,650 ширхэг тарьцыг аймгийн албан байгууллагын хүсэлтийн дагуу өгсөн байна. Нийт мод үржүүлгийн газарт 13 төрлийн 232,125 ширхэг тарьц ургаж, сургалтын төвийн үйл ажиллагаатай давхардсан тоогоор 350 гаруй зочид ирж танилцсан байна.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь төрөөс ойн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, Монгол-Солонгосын Ногоон хэрэм төслөөс хүлээн авсан ойн зурвас, мод үржлийн газрын хэвийн үйл ажиллагааг хангах зорилготой ажлууд хийгдсэн байна.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн анги нь 17 орон тоотойгоор ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн даргын тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. Энэхүү баримт бичигт Лүн суман дахь сум дундын Ойн ангийн бүртгэл тайлагналын онцлогийг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,588.7 мянган төгрөгөөр буюу 90,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	20,232.0		-20,232.0
Бараа материал	8,997.5	21,250.6	12,253.1
Үндсэн хөрөнгө	30,818.8	93,386.4	62,567.6
Нийт хөрөнгө	60,048.3	114,637.0	54,588.7
Өр төлбөр		2,855.1	2,855.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	60,048.3	111,781.9	51,733.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	60,048.3	114,637.0	54,588.7

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эхний үлдэгдэл 20,232.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг буюу бусад зардлын тооцооны авлага 20,232.0 мянган төгрөгөөр буурсан байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 8,997.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 21,250.6 мянган төгрөг буюу худалдан авсан хөрөнгө 12,253.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 60,048.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 114,637.0 мянган төгрөг болж, 54,588.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 5,203.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 74,970.0 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5,203.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, худалдан авч, Байгаль орчин аялал, жуулчлалын яамнаас 74,970.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 0 төгрөг, эцсийн үлдэгдэл 2,855.1 мянган төгрөг болж 2,855.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Энэ нь аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/13 тоот захирамжаар тус байгууллагын орон тоо бүтцийг 42 байхаар баталсан байна.

Тус байгууллага тайлант онд цалингийн зардлаас үндсэн 7 ажилтан, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 10 гэрээт ажилчдын цалин олгож, төсөвт орон тоо, цалингийн зардлыг дутуу баталснаас НДШ, ХАОАТ-т өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 111,781.9 мянган төгрөг болж 51,733.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 135,906.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас Лүн суман дахь сум дундын Ойн ангийн үйл ажиллагааны зардлыг 46,524.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 182,430.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь гэрээтийн орон тоо нэмэгдсэнээс цалин, НДШ, бусад зардлыг 46,524.2 мянган төгрөгөөр нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 182,430.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 182,430.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төвлөрүүлсэн мөнгө байхгүй байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 182,430.3 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ойжуулалт-үндсэн үйл ажиллагааны зардал	67,430.0	67,430.0	0	100
2	Ойжуулалт-гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	115,000.0	115,000.0	0	100
	Дүн	182,430.0	182,430.0	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 20,232.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн анги тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гэрээт ажилчдын цалин, НДШ-ийн зардалд 20,232.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт ийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71403-Ойжуулалт	2022.01.01-2022.12.31	Байгалийн үнэ цэнэ өгөөжийг үнэлэн хамгаалж байгалийн баялгийг нөхөн сэргээж хомсдолыг буруулж ногоон хөгжил болон иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж Тэр бум модны хөдөлгөөнийг өрнүүлж иргэд албан байгууллагыг идэвхжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	182,430.3	182,430.3

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын ИТХ-аас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны батлагдсан 182,430.3 мянган төгрөгийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 2,736.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,052.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн анги нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 89,4 хувь, 5,0 саяас дээших орлогын 13 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээ байршуулахаас 202,662.3 мянган төгрөгийн орлогын 13 гүйлгээ байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар үлдэгдэл төвлөрүүлээгүйтэй холбоотой 1 төлбөрийн акт, томилолтын зардалтай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Лүн суман дахь сум дундын Ойн ангийн даргын 2022 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн 16 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	476.8	1	476.8	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	750.0	1	750.0	100
Нийт дүн	2	1,226.8	2	1,226.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2023 оны төсөвт орон тоо бүтэц, цалингийн зардал батлагдсан эсэх

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,597.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7,597.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 7,597.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцсон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 320,154.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 2,855.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 317,299.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд НДШ, ХАОАТ өр 2,855.0 мянган төгрөгөөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх,” болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд Лүн суман дахь Ойн ангийн даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/56 тоот тушаалаар томилогдсон комисс хөрөнгийн тооллогыг хийж, нягтлан бодогч 114,637.0 мянган төгрөгийн хөрөнгийн тооцоо бодоогүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Хөрөнгийн тооллогын тооцоо бодож байх.

2. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 202,662.3 мянган төгрөгийн 13 гүйлгээ байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг зөрүүтэй тооцсон	1	7,597.2			1	7,597.2	1	7,597.2		
Дүн	1	7,597.2			1	7,597.2	1	7,597.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд НДШ, ХАОАТ өр үүсгэсэн байна	1	2,855.0			1	2,855.0		
Лүн суман дахь Ойн ангийн даргын хөрөнгийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/56 тоот тушаалаар томилогдсон комисс тооллого хийж, нягтлан бодогч хөрөнгийн тооцоо бодоогүй зөрчил илэрлээ.	1	114,637.0					1	114,637.0
Дүн	1	117,492.0			1	2,855.0	1	114,637.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 13 гүйлгээ байршуулаагүй	1	202,662.3			1	202,662.3
Дүн	1	202,662.3			1	202,662.3
Дүн						
Нийт дүн	1	202,662.3			1	202,662.3